



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/81

Жаргалтхаан сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны A/246 дугаар захирамж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ардын хувьсгалын 104 жил, Жаргалтхаан сум үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулахад зориулж 20,000,000 (хорин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд зарцуулагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын төсвийн Улсын их баяр наадмын зардлаас гаргаж тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА  С.ГАНБАТ